CHOSUN UNIVERSITY

2026 оны 2-р улирал

# Солонгос Хэлний Бэлтгэлийн Элсэлтийн Удирдамж




조선대학교
CHOSUN UNIVERSITY

CHOSUN UNIVERSITY 1946

# Гарчиг

2026оны 2-р улирлын Солонгос хэлний бэлтгэлийн элсэлтийн удирдамж


01 Өргөдөл гаргахад тавигдах шаардлага ............ 2

02 Сургалтын хуваарь ............ 2

03 Сонгон шалгаруулалтын хуваарь ба журам ............ 2

04 Сонгох шалгаруулах арга ............ 3

05 Өргөдөл гаргах баримт бичиг ............ 3

06 Гэрчилгээ/Диплом нотлох баримт бичгийн заавар ............ 4

07 Бүртгэлийн арга ............ 5

08 Тэтгэлэг ............ 5

09-12 Бусад мэдээлэл ............ 6

13 Анхаарах зүйлс ............ 8

## 01 Өргөдөл гаргахад тавигдах шаардлага

1. Элсэгчийн эцэг эх болон өөрөө хоёулаа гадаад улсын иргэнбайх.
2. Солонгос улсад болон гадаад оронд ахлах сургууль төгссөн, эсвэл түүнтэй адил болов сролын түвшин эзэмшсэн байх.

## 02 Сургалтын хуваарь

| Он | Семестр | Улирал | Сургалтын хугацаа | Хичээллэх цаг | Сургалтын төлбөр |
|---|---|---|---|---|---|
| 2026 | 1-р улирал | хавар | 2026.03.04. ~ 2026.05.12. | 20долоо хоног (400цаг) | 2,550,000вон (сурах бичиг багтсан ) |
| | | зун | 2026.05.26. ~ 2026.08.03. | | |
| | 2-р улирал | намар | 2026.09.02. ~ 2026.11.17. | 20долоо хоног (400цаг) | 2,550,000вон (сурах бичиг багтсан ) |
| | | өвөл | 2026.11.23. ~ 2027.02.02. | | |

※ Энэхүү сургалтын хуваарь нь сургуулийн дотоод нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгдөж болзошгүй.

## 03 Сонгон шалгаруулалтын хуваарь ба журам

| Ангилал | 2026оны 2р улирал (намрын элсэлт) | 2026оны 2р улирал (Өвлийн элсэлт) | Тайлбар |
|---|---|---|---|
| Онлайн өргөдөл хүлээн авах | 2026.05.29.~06.19. | 2026.09.01.~09.18. | https://www3.chosun.ac.kr/global |
| Материалын шалгалт ба ярилцлага | 2026.06.22. ~2026.07.03. | 2026.09.21. ~ 2026.10.08. | заасан хугацаанд материалын эх хувийг ирүүлсэн байх бөгөөд цахимаар ярилцлагад орно |
| Элсэлтийн хариу зарлах | 2026.07.07. | 2026.10.12. | https://www3.chosun.ac.kr/global → Admission→ Admission Result |
| Сургалтын төлбөр төлөх | 2026.07.07.~ 07.10. | 2026.10.12.~10.14. | Төлбөрийн нэхэмжлэл и—мэйлээр илгээгдэнэ |
| Элсэлтийн зөвшөөрөл олгох | 2026.7сүүл | 2026.10сүүл | БНСУ-н элчинд визний хүсэлт гаргана |
| Хичээл эхлэх өдөр | 2026.09.02. | 2026.11.23 | |

※ Бүх мэдэгдэл, хариу имэйлээр илгээгдэх тул зөв, идэвхтэй имэйл хаяг оруулах шаардлагатай.
※ Элсэлтийн хугацаа өөрчлөгдсөнтохиолдолд албан ёсоор их сургуулийн вэб сайтад зарлагдана.

## 04 Сонгох шалгаруулах арга

1. Элсэгчийн өөрийн танилцуулга, дүнгийн үзүүлэлт, суралцах чадвар, санхүүгийн чадамж, өргөдлийн замнал зэрэг үзүүлэлтэд үндэслэн Элсэлтийн комиссын шийдвэрээр шалгаруулна.
2. Материалын үнэлгээний дүнд суралцах болон санхүүгийн чадамж хангалтгүй гэж үзвэл бүртгэлийн тооноос үл хамааран тэнцүүлэхгүй байх боломжтой.

## 05 Өргөдөл гаргах баримт бичиг

| No. | Баримт бичгийн нэр | Тайлбар |
|---|---|---|
| 1 | Элсэлтийн өргөдлийн маягт | • Онлайн өргөдлийг хэвлэж гарын үсэг зурна.<br>(Паспорт дээрх англи нэр, хаяг, холбоо барих дугаар, төгссөн сургуулийн албан ёсны нэрийг заавал бичнэ.) |
| 2 | Өөрийн танилцуулга | |
| 3 | Суралцах төлөвлөгөө | |
| 4 | Хувийн мэдээлэл ашиглах зөвшөөрлийн хуудас | |
| 5 | Цээж зураг | • 2 ширхэг (Цагаан Фонтой, 3.5cm × 4.5cm хэмжээтэй.) |
| 6 | Паспортын хуулбар | • Өнгөт хуулбар байх ёстой. |
| 7 | Сүүлд төгссөн сургуулийн гэрчилгээ эсвэл диплом | • БДБ гэрчилгээ/ Дипломын апостиль гэрчилгээ<br>① апостиль гэрчилгээ<br>② Сургалтын мэдээлэл шалгах зөвшөөрлийн хуудас. (сургуулийн заг вар бөглөх) |
| 8 | Дүнгийн тодорхойлолт | • Төгссөн сургуулийн бүх улирлын хичээлийн дүнг багтаасан байх. |
| 9 | Банкны тодорхойлолт | • Виз мэдүүлэх өдрөөс 30 хоногийн дотор олгогдсон ₩8,000,000 (найман сая вон)-оос дээш дүнтэй банкны англи хэл дээрх Үлдэгдэлийн лавлагааны тодорхойлолт (эх хувь).<br>※ Өөрийн эсвэл эцэг/эхийн нэр дээр гаргасан байх. |
| 10 | Иргэний харьяалал болон гэр бүлийн харилцааны баримт | ① Өөрийн болон эцэг/эхийн паспорт эсвэл Иргэний үнэмлэхийн лавлагаа (e-mongolia лавлагаа)<br>② Өөрийн болон эцэг эхийн гэр бүлийн харилцааг нотлох баримт бичиг (эх хувь эсвэл нотариатаар баталгаажсан хувилбар).<br>- Төрсөний гэрчилгээний лавлагаа (e-mongolia лавлагаа) эсвэл төрөл садангийн лавлагаа<br>※ Хэрэв эцэг эх нь салсан эсвэл нас барсан бол үүнийг нотлох төрийн байгууллагын лавлагаа.<br>※ Англиас өөр хэл дээрх бичиг бол англи орчуулгатай нотариат заавал хавсаргах.<br>※ Элсэлтийн материалын хугацаанаас 3 сарын дотор олгогдсон бичиг баримтыг хүчинтэйд тооцно. |

| | | |
|---|---|---|
| 11 | Санхүүгийн баталгааны бичиг баримт | • Санхүүгийн баталгаалагч (эцэг/эх)-ийн ажлын тодорхойлолт、орлогын бичиг.<br>• Хэрэв бизнес эрхэлдэг бол: Компаний улсын бүртгэлийн гэрчилгээ болон татварын тодорхойлолт.<br>※ Ажлын тодорхойлолт нь компанийн нэр, хаяг, холбоо барих, албан тушаал, гарын үсэг болон албан тамгатай байх ёстой.<br>※ Албан ёсны бичиг баримт нь англи эсвэл солонгос хэлээр байх, бусад хэл бол орчуулгын нотариаттай байх ёстой. |
| 12 | Бусад бичиг баримт : хамааралтай хүмүүсд | • Хоосон хугацааны нотолгоо: Сургуулиа төгссөний дараа 6 сараас дээш хугацаа өнгөрсөн бол тухайн хугацаанд хийсэн үйл ажиллагааг нотлох материал (ажлын тодорхойлолт, гэрчилгээ гэх мэт).<br>Одоогоор ажил эрхэлж буй бол: Ажлын тодорхойлолт, суралцах шалтгааны тайлбар.<br>Өмнө нь Солонгост суралцаж байсан бол холбогдох баримт бичгийг заавал гаргах. |
| 13 | Солонгост оршин суугчийн нэмэлт материал | • Гадаад иргэний үнэмлэхийн хуулбар (хоёр тал).<br>- Солонгост оршин суугаа виз эзэмшигч нь өргөдөл гаргахаас өмнө хариуцсан ажилтантай заавал зөвшилцөнө. |

# 06 Сургалтын гэрчилгээ нотлох баримт бичгийн заавар

**1. Хятад улсаас бусад орнуудын хувьд**

a. Апостиль конвенцид нэгдсэн улсын иргэд боловсролын зэргээ нотлох баримт бичгээ Апостиль (Apostille) баталгаажуулалттайгаар өгөх ёстой.

- Апостиль конвенц нь конвенцид нэгдсэн улс орнуудын хооронд гадаад албан баримт бичгийг баталгаажуулах нэмэлт консулын баталгаажуулалтын шаардлагыг хүчингүй болгодог олон улсын гэрээ юм.("Гадаад баримт бичгийн баталгааг заавал шаардахгүйгээр тус конвенц"-д нэгдсэн улсын хувьд Апостиль баталгаа орлох хүчтэй.)
- Апостиль гэрчилгээ авах арга

Баримт бичиг бэлдэх → ГХЯ-д очих → Apostille хүсэлт → Apostille хяналт → Apostille олгогдох

**A. Хаагийн конвенцид нэгдээгүй улсын хувьд тухайн улсын Солонгос Элчин сайдын яам эсвэл Солонгост байрлах тухайн улсын Элчин сайдын яамны баталгаа авсан байх ёстой.**

**2. Хэрэв хамгийн сүүлд төгссөн сургууль Хятадад байрладаг бол**

- Боловсролын баталгаажуулалтын гэрчилгээ (CHSI)-г англи хэл дээр гаргуулж авах болон өөр бусад аргаар гаргах боломжтой

# 07 Бүртгэлийн арга

| Ангилал | агуулга |
|---|---|
| Онлайн | [https://www3.chosun.ac.kr/global] → [Admission] → [Apply] → "Korean Language Course Admission" |
| Биечлэн хүргэх | 광주광역시 동구 조선대5길 9<br>조선대학교 국제관 1층 국제협력팀(61452) 한국어연수 담당자<br>International Affairs Team 'Korean language Program Coordinator', Chosun University, 9, Chosundae 5-gil, Dong-gu, Gwangju, Republic of Korea<br>Tel. +82-62-230-6789/6956<br>※ Хугацаанд ирсэн материал хүчинтэйд тооцогдоно. |

# 08 Тэтгэлэг

| Төрөл | Төрөл | урамшуулал | тайлбар |
|---|---|---|---|
| Сургалтын амжилтын тэтгэлэг1 | Ангийн 1р байр | Сургалтын төлбөрийн 20% | улирал бүр |
| Сургалтын амжилтын тэтгэлэг2 | Ангийн 2р байр | Сургалтын төлбөрийн 15% | |
| Сургалтын амжилтын тэтгэлэг3 | Ангийн 3р байр | Сургалтын төлбөрийн 10% | |
| Топик онооны тэтгэлэг | TOPIK 4с дээш түвшин | ₩500,000 | 1 нэг удаа |
| Элсэх тэтгэлэг | Их сургуулийн үндсэн хөтөлбөрт элсвэл | ₩500,000 | 1 нэг удаа |

# 09 Хэлний бэлтгэлийн оюутанд олгох боломжууд

1. Солонгос соёлын хөтөлбөрт үнэ төлбөргүй оролцох боломж
2. Үлирал бүрийн шилдэг сурагчдад тэтгэлэг олгох
3. TOPIK 4-р түвшин болон түүнээс дээш дүнтэй сурагчдад ₩500,000-ын шагнал
4. Солонгос хэлний сургалтын “Оюутан дэмжигч” хөтөлбөрт оролцох боломж

# 10 Дотуур байр

1. Элсэгч нь дотуур байранд эсвэл гадуур амьдрах боломжтой бөгөөд бүртгэл хийсний дараа байр солих боломжгүй.
2. Элсэхэд сүрьеэгүй гэсэн эмнэлгийн тодорхойлолтгаргаж өгөх шаардлагатай.
3. Дотуур байранд амьдарч буй бүх оюутан улирал бүр эрүүл мэндийн үзлэгт заавал хамрагдана.Халдварт өвчтэй, сэтгэцийн эмгэгийн шинжтэй бол дотуур байранд байрлуулах боломжгүй.

## A. Дотуур байрны танилцуулга

| Ангилал | Байрны төлбөр | | Тайлбар | Хугацаа |
|---|---|---|---|---|
| | төлбөр | төрөл | | |
| Бэкхагса | ₩812,000 | 2 хүний өрөө | Нийтийн нойл•шуршуур, оюутны хоолны газар | 4 сар |
| | ₩1,218,000 | 1 хүний өрөө | Хувийн нойл шуршуур оюутны хоолны газар | |
| Глобал хаус | ₩954,000 | 2 хүний өрөө | Өрөөн доторх ариун цэврийн өрөө, оюутны хоолны газар | |
| | ₩1,431,000 | 1 хүний өрөө | | |
| Грийн виллиж | ₩812,000 | 2 хүний өрөө | Өрөөн доторх ариун цэврийн өрөө | |

## B. Дотуур байранд урьдчилж орох заавар

| Байр | 1өдрийн төлбөр | | Тайлбар |
|---|---|---|---|
| | 1 хүний өрөө | 2 хүний өрөө | |
| Бэкхагса, Грийнвиллиж | ₩13,500 | ₩9,000 | Урьдчилан хүсэлт гаргаж, төлбөр төлсний дараа орж болно. |
| Глобалхаус | ₩16,500 | ₩11,000 | |

※ хугацааг улирал эхлэхээс өмнө мэдэлэл өгнө

- Хугацааг тодорхой болсны дараа мэдэгдэнэ
- Дотуур байрны оюутнууд улирал бүр эрүүл мэндийн шилжилээнд хамрагдах
- 1 хүний ор, ширээ (номын тавиуртай), сандал, хувцасны шүүгээ (толь, гутлын тавиуртай), интернетийн LAN кабель, утас, орны дэвсгэр, хөшиг.
- Хувийн бэлтгэл (Ор хөнжлийн даавуу, дэр, хувийн ариун цэврийн хэрэгсэл, өлгүүр, тавчик)
- Хамтын гал тогооноос бусад газар хоол хийх хатуу хориглоно.
- Нэмэлт мэдээлэл: [Дотуур байрны цахим хаяг: (https://chosun.ac.kr/csu/78aT1002nS/ul.do)] сайт ад дэлгэрэнгүй мэдээлэл байрлана.

### C. Хооллолт — Дотуур байрны хоол

| Байр | Хоолны Сонголт | |
|---|---|---|
| Хоолны Сонголт | 1 өдрийн 1 хоол<br>(75хоол 1хоолны ₩4,200) | 1 өдрийн 2 хоол<br>(150хоол 1хоол ₩3,900) |
| | ₩315,000 | ₩585,000 |

- 1 өдрийн 1 хоол эсвэл 2 хоолын аль нэгийг заавал сонгоно.
- Хоолны сонголт хийгээгүй бол дотуур байранд амьдрах эрх цуцлагдах бөгөөд дараагийн улиралд дотуур байранд бүртгүүлэх боломжгүй.
- Сургалтын явцад хоолны тоо өөрчлөх боломжгүй.
- Хоол нэмэлтээр авахыг хүсвэл сургалт эхэлсний дараашимтгэл төлж, хоолны картыг дахин цэнэгл энэ. (1 өдрийн 2 хоолын үед нэг хоол ₩3,900)
- Хоолны төлбөр нь дотуур байрны төлбөртэй хамт нэг дор төлөгдөнө.

# 11 Бусад мэдээлэл

1. Шинэ элсэгчийн чиглүүлэх уулзалт хичээл эхлэхээс өмнөх баасан гарагт зохион байгуулагдана.
   - Элсэгч бүр заавал оролцоно (Гадаад иргэний үнэмлэх авах, эрүүл мэдийн даатгал, виз, сургалтта й холбоотой мэдэлэл).

2. Даатгал:
   - Гадаад иргэний бүртгэл хийснээс хойш 6 сарын дараа “Үндэсний эрүүл мэндийн даатгал”

   Үүнээс өмнө 6 сарын хувийн даатгалд хамрагдах шаардлагатай (₩70,000 / 6 сар) -д автоматаар хамрагдана.

3. Үлсын эрүүл мэндийн даатгалын шимтгэл:
   а. Даатгалд хамрагдах өдөр: Гадаадыниргэний бүртгэл хийсний дараа автоматаар даатгалд хамрагдан
   - Гадаад иргэний бүртгэл хийснээс хойш 6 сарын дараа “Үндэсний эрүүл мэндийн даатгал”

   Үүнээс өмнө 6 сарын хувийн даатгалд хамрагдах шаардлагатай (₩70,000 / 6 сар) -д автоматаар хамрагдана.
   - Гадаадын иргэний бүртгэл (외국인등록) дуусахаас өмнө даатгалд хамрагдах боломжгүй.

   Бүртгэл дуусаагүй байх хугацаанд эмнэлэг ашиглах шаардлагатай бол аюулгүй байдлын үүднээс тусдаа хувийн даатгал хийлгэхийг зөвлөж байна.

   б. Үндэсний эрүүл мэндийн даатгалын шимтгэл: 79,320 вон
   - Энэ дүн нь 2026 оны стандарт бөгөөд цаашид нэмэгдэх боломжтой.
   - Солонгост 6 сараас дээш хугацаагаар оршин суух тохиолдолд, гадаадын иргэний бүртгэл хийсэн өдрөөс эхлэн заавал даатгалд хамрагдана.

   в. Төлбөр төлөх арга: Оршинсуугаа хаяг руу төлбөрийн нэхэмжлэх (고지서) илгээгдэнэ. Нэхэмжлэх дээрх дүн болон дансны дугаарыг шалгаж төлнө.
   - Автомат суутгал (자동이체) / Картаар төлөх / Даатгалын байгууллагын салбарт биечлэн очиж төл өх/Банк дээр очиж төлөх

# 12 Солонгост ирэхэд шаардагдах зардал

1. Солонгост ирэхээс өмнө хувийн хэрэгцээний зардалд шаардлагатай мөнгөө солихыг зөвлөж байна.
2. Солонгост ирсний дараах анхны суурьших зардал(хувийн зардал хасаад) : 1,374,000вон(ойролцоогоор)

| Төрөл | Төлбөр | Бусад |
|---|---|---|
| Эрүүл мэндийн даатгал | ₩70,000 | 6сар (Хувийн даатгалын шимтгэл төлнө, 6 сарын дараа улсын эрүүл мэндийн даатгалд хамрагдана.) |
| Гадаад иргэний үнэмлэхний хураамж | ₩35,000 | |
| Дотуур байр | ₩1,269,000 | Глобал хаус( 1хоолтой) |
| Нийт | ₩1,374,000 | |

# 13 Анхаарах зүйлс

1. Бүх мэдээллийг бүрэн оруулж, материалын эх хувийг шуудангаар эсвэл биечлэн хүргэж өгөх ёстой. материал хүлээн авах хугацаанд ирсэн тохиолдолд бүртгэл хүчинтэйд тооцогдоно.
2. Давхар иргэншилтэй болон иргэний харьяалалгүй хүмүүс элсэх боломжгүй.
3. Цахим шуудан болон утасны дугаарыг зөвхөн өргөдөл гаргагчийн хувийн мэдээллээр бөглөх ба буруу эсвэл бусдын мэдээллийг оруулснаас үүдэлтэй хохирлыг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.4. Бүх баримт бичгийг солонгос эсвэл англи хэл дээрх эх хувиар (өөр хэл дээр бол баталгаат орчуулгатай байх), өнгөтөөр сканнердан PDF файл хэлбэрээр  илгээж, дараа нь эх хувийг шуудангаар эсвэл биечлэн хүргэж өгөх ёстой.
5. Онлайн бүртгэлийг хийсэн байсан ч шаардлагатай баримт бичгийг хугацаанд нь хүргүүлээгүй тохиолдолд тэнцээгүйд тооцно.
6. Хуулбар баримт бичиг өгсөн тохиолдолд хугацаанд нь эх хувийг заавал хүргэж өгөх ба эх хувьтайгаа зөрүүтэй бол хариуцлага хүлээнэ.
7. Баримт бичгийг хуурамчаар үйлдэх, засварлах, эсвэл хууль бус аргаар элсэлт авсан нь тогтоогдвол элсэлтийг хүчингүй болгоно.
8. Шуудангаар илгээсэн материалын ирсэн эсэхийг шалгах асуулт авахгүй ба ирүүлсэн материалуудыг буцаан өгөхгүй.
9. Виз мэдүүлэх зэрэг шалтгаанаар дипломын эх хувийг өгөх боломжгүй бол нотариатаар баталгаажуулсан хуулбарыг түрүүлж өгөөд, дараа нь эх хувийг хүргэж өгөх боломжтой.
10. Шалгалтын явцад шаардлагатай тохиолдолд нэмэлт материал шаардаж болно, заавал өгөх материал дутуу бол шалгалтад тэнцэхгүй.
11. Материал дээрх нэр нь ялгаатай бол, ижил хүн болохыг нотолсон тухайн улсын шүүхийн гэрчилгээ хавсаргах ёстой.
12. Солонгос эсвэл англи хэлнээс бусад хэл дээрх бүх материалд баталгаат орчуулгын хувилбар хавсаргах шаардлагатай.
13 Элсэлтийн удирдамжид тусгагдаагүй асуудлыг их сургуулийн Олон улсын хамтын ажиллагааны алба шийдвэрлэнэ.
14. Элсэлтээс хасагдсан өргөдөл гаргагчийн сургалтын төлбөрийн буцаан олголтын гүйлгээний шимтгэлийг өргөдөл гаргагч өөрөө хариуцна.
15. Элсэлтийн дүн гарсны дараа, виз авсан өргөдөл гаргагчийг эцсийн байдлаар тэнцсэнд тооцно. Хэрэв хичээл эхлэхээс өмнө виз гараагүй бол дараагийн улиралд элсэх зарчмыг баримтална.
16. Элсэлт баталгаажсан гадаад оюутнууд Солонгост заавал эрүүл мэндийн даатгалд хамрагдах ёстой.
17. Энэхүү элсэлтийн удирдамж нь солонгос, англи, хятад, монгол хэлээр бичигдсэн бөгөөд тайлбарын зөрүү гарсан тохиолдолд солонгос хэл дээрх хувилбарыг албан ёсны гэж үзнэ.

SINCE 1946

HUMANITY BEYOND *the* FUTURE

휴머니티, 혁신의 미래 ╲ 조선대학교

**CHOSUN UNIVERSITY**

Korean Language Program

**국제협력팀**

광주광역시 동구 조선대5길 9, 조선대학교(국제관 1층) 국제협력팀 '한국어연수담당자'
우편번호: 61452
전화번호: 062-230-6789 / 062-230-6956

**International Affairs Team 'Korean Language Program coordinator**

International Building 1st floor, Chosun University, Chosundae5gil 9, Dong-gu, Gwangju
Postal code: 61452
Office: +82-62-230-6789 / 6956

E-mail: admission@chosun.ac.kr / suhyeon@chosun.ac.kr / anudr@chosun.ac.kr
https://www.chosun.ac.kr/eng